



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/321

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 58 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 58 дугаар тушаалаар Улсын Онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабыг байгуулж штабын бүтэц, ажиллах журмыг баталсантай холбогдуулан коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээ, болзошгүй газар хөдлөлт болон бусад гамшгийн хор уршгийг арилгах, салбар хоорондын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах аймгийн Онцгой комиссын "Шуурхай штаб"-ын бүтэц, ажиллах журмыг шинэчлэн боловсруулж батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээ болзошгүй газар хөдлөлт болон бусад гамшгийн хор уршгийг арилгах, салбар хоорондын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах Онцгой комиссын "Шуурхай штаб"-ын бүтэц, ажиллах журмыг боловсруулж, танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай


3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний ажлын явц, холбогдох мэдээллийг тухай бүр нь танилцуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай..

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210517



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч: М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Л.Дорждэрэм (Онцгой комиссын нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч)

Гишүүд:

Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Б.Алтантөгс (Эрүүл мэндийн газрын дарга)

М.Адъяабаатар (Онцгой байдлын газрын дарга)

Б.Мөнхбат (Цагдаагийн газрын дарга)

Ш.Төрбат (Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Б.Мөнхбат (Тагнуулын хэлтсийн дарга)

С.Бат-Оргил (Сайнцагаан сумын Засаг дарга)

Л.Баярсайхан (Засаг даргын Тамгын газрын

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)